



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/119

Улаанбаатар хот

Нийслэлийн Өргөө амаржих газрын эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 4,350,000.00 (дөрвөн сая гурван зуун тавин мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Жаргалант тосгоны эрүүл мэндийн төвийн баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Өргөө амаржих газар (Н.Батсайхан)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Жаргалант тосгоны эрүүл мэндийн төв (Г.Батжаргал)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГА



В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны 06 дугаар сарын... -ны өдрийн... дугаар тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Нийслэлийн Өргөө амаржих газар

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл /2022 оны ... сарын ...-ны өдрийн байдлаар/	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн авах байгууллага
1	Эмчилгээний ор	2015.04.16	ш	15	290,000.00	4,350,000.00	4,350,000.00	-	Нийслэлийн Өргөө амаржих газар	Нийслэлийн жаргалант тосгоны эрүүл мэндийн төв
	Дүн			15		4,350,000.00	4,350,000.00	-		